



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБОМ ЭДЭЭ

170 /170/ 2021.11.03

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Г.САЙХАНБАЯР: БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР ҮЙЛДВЭРЛЭГЧ, БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ САЛБАР БОЛНО

Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын сайд Ч.Номин, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нар 2022 оны төсвийн танилцуулга ээлжит уулзалтад оролцож салбарын төсөв, санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, ирэх оны төсвийн төслөө сэтгүүлчдэд танилцуулж, батлан хамгаалах, эрчим хүч, соёлын салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын явцын талаар мэдээлэл өгч, сэтгүүлчдийн асуултад хариулт өглөө.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр энэ үеэр "Аливаа төсөв бол бодлоготойгоо уялдаж явах ёстой. Харамсалтай нь батлан хамгаалах салбарын хувьд төсөв нь хөгжлийн төсвийн хэмжээнд өнөөдрийг хүртэл хүрч чадаагүй. Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050", "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгүүд, мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах, Зэвсэгт хүчний шинэчлэлтэй холбоотойгоор нэлээд том зорилтуудыг тусгасан заалтуудыг тодорхойлсон байгаа. Ялангуяа 2050 он хүртэлх 30 жилийн хугацаанд бид юу хийх вэ гэдэг алсын хараа юм.

(Үргэлжлэл нь II нүүрт)



Түүхэнд энэ өдөр

1912 он.
Монгол-Оросын хэлэлцээр болон протоколд Нийслэл Хүрээнд гарын үсэг зурав.

1924 он.
С.Магсаржав, штабын дарга М.Косичийн хамт ЗОУ-д айлчлан Улаан армийн зохион байгуулалт, улс төрийн ажлын туршлагатай танилцав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
6	-10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,851.0	2,853.0
EUR	3,310.0	3,320.0
CNY	445.20	446.30
RUB	40.30	41.20
JPY	25.00	25.20
KRW	2.39	2.41

ЗУРХАЙ

2021.11.03 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 28/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ДОЛООН УЛААН ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.40-17.31
БАРИЛДЛАГА:
Үл зохилдох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Сэрэхүй
Суудал:
Огторгуй

Аргын тооллын 11 сарын 3, Буд гараг. Билгийн тооллын 28, Тэргүүн дагуул одтой, хөхөгчин туулай өдөр. Өдрийн наран 7 цаг 40 минутад мандан, 17 цаг 31 минутад жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба гарагийг тахиж, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хяравас гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ТОХИЖИЛТЫН АЖИЛТАЙ ТАНИЛЦЛАА



Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх "Монгол цэрэг-Энхийн төлөө" цогцолборын тохижилт, бүтээн байгуулалтын ажлын явцтай Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай тэргүүтэй албаны хүмүүс өчигдөр танилцлаа. Иргэдийн амралт чөлөөт цагийг ая тухтай өнгөрүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд залууст цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх, энхийг сахиулах үйл ажиллагааг сурталчлах зэрэг олон талын ач холбогдолтой тус цогцолборын бүтээн байгуулалтын ажил батлагдсан зураг төслийнхөө хүрээнд шат дараатай хэрэгжиж байна.

Тодруулбал, өнгөрсөн жил "Энхийн төлөө" хөшөө, жагсаалын талбай, авто зогсоол хийгдсэн бол өнөө жил БХЯ-ны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд БХЯ-ны хөрөнгө оруулалтаар явган хүний болон дугуйн зам, гэрэлтүүлэг зэргээр тохижилтын нэлээд ажлыг өрнүүлж байгаа аж. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачлан хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус цогцолборын байрлалд 200 ширхэг гацуур мод тарьсан бөгөөд цаашид ногоон төгөл болохоор зорьж байгаагаар албаныхан онцоллоо. Энэхүү тохижилтын ажилд Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар болон Тусгай хүчний цэргийн командлалын алба хаагчид идэвхтэй оролцож байна.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 355,433 +1021	ЭДГЭРСЭН 534,158	НАС БАРСАН 1,631 +10
-----------------------------------	---------------------	-------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6090 +105	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 174	ЭДГЭРСЭН 5798
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 248,223,821	Эдгэрсэн Нийт: 224,900,353	Нас барсан Нийт: 5,027,501
--------------------------------	-------------------------------	-------------------------------

Г.САЙХАНБАЯР: БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР ҮЙЛДВЭРЛЭГЧ, БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ САЛБАР БОЛНО

(Түрүүч нь I нүүрт)

Бид 2030 он гэхэд дэлхийн жишигт хүрсэн өндөр чадамжтай мэргэшсэн чадварлаг Зэвсэгт хүчинтэй болсон байна гэдэг том зорилтыг дэвшүүлсэн. Гэхдээ энэ нь хүний хөгжилд хамаатуулж ойлгох эсвэл том амлалт өгөөд хэрэгжих асуудал бий харин төсөв хөрөнгө, хөгжлийн бодлогоор шийдэх асуудал юм. Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрт Засгийн газрын дунд хугацааны буюу үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн заалтууд байдаг. Энэ хоёр баримт бичиг нь харилцан уялдаатай нэг зорилго, агуулгатай. Зэвсэгт хүчний хувьд ойрын жилүүдэд Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд салбарын үндсэн зорилтыг хангахаар төлөвлөсөн батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлууд юм.

Эдгээр нь "Алсын хараа-2050", Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрт суусан бодлогын том заалтууд. Мөн манай салбарын хувьд бидний хүрэх түвшнийг тодорхойлсон хөрөнгө шаардсан ийм тодорхой 10 ажил байгаа.

Тухайлбал, сумны үйлдвэр байгуулах, улсын агаарын хилийн системийн чадавхыг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний удирдлагын төвийн барилгыг шинээр барих, Кибер аюулгүй байдлын Зэвсэгт хүчний Дата төвийг байгуулах, Агаарын цэргийг дунд оврын төсвөг тэргээр хангах, Налайхын аэродромын үндсэн зурвасыг сэргээн засварлах, газрын тоног төхөөрөмжийг шинэчлэх, Зэвсэгт хүчний анги,

байгууллагын мэдлийн тусгай хэрэгцээний газарт албан тушаалын орон сууцыг барих ажлыг үргэлжлүүлэх зэрэг ажлууд бий. Мөн ҮБХИС-д Нэгдсэн лабораторийн барилга барих, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарыг туулах чадвар сайтай тусгай зориулалтын хөнгөн болон хуягласан цэргийн техникээр хангах, Барилга-инженерийн цэргийн ангийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, Цэргийн II шатны эмнэлгийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, галт хэрэглэлийн нөөцийг шилжүүлэн байрлуулах гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн" гэлээ.

Батлан хамгаалахын сайдын танилцуулсан эдгээр 10 зорилтоос 5 нь хэрэгжих шатандаа явж байгаа бөгөөд тодорхой үр дүнд хүрсэн гэв. Тухайлбал, Барилга-инженерийн цэргийн бүтээн байгуулалтын ажил сүүлийн хоёр жил тасралтгүй явагдаж байгаа бол Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарыг дотооддоо үйлдвэрлэсэн туулах чадвар сайтай тусгай техникээр хангах ажлын эхлэлийг энэ онд тавьсан байна. Өөрөөр хэлбэл, тодорхой тооны цэргийн техникийг дотооддоо үйлдвэрлэсэн гэсэн үг.

Мөн Налайхын аэродромын үндсэн зурвасыг сэргээн засварлах, газрын тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг Агаарын цэрэгт хийгдэх ажил эхэлсэн явж байгаа юм. Харин бага бууны сумны үйлдвэртэй болох зорилтын тухайд ирэх оны төсвийн хөрөнгө оруулалтад заалт нь туссан. Эдгээр 10 зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд энэ 4 жилийн хугацаанд Засгийн газраас Батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний хөгжүүлэхэд чиглэсэн бодит ажлууд болно гэдгийг сайд Г.Сайханбаяр онцолсон.

Тэрээр үүний дараа батлан хамгаалах салбарын 2021 оны төсвийн ерөнхий байдлыг мэдээлэв.

Батлан хамгаалах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүн болон улсын төсөвт эзлэх хувь хэмжээ тодорхой жишигтэй. Сүүлийн жилүүдэд тус салбарын төсвийн улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ 0,6-0,9 хувьд хэлбэлзэж байгаа гэсэн тоон үзүүлэлт гарсан байдаг. Үүгээрээ батлан хамгаалах салбарт төсөв зарцуулдаг 145 орноос Монгол Улс 115 дугаар байрт бичигдэж байна. Энэ хувь хэмжээг дэлхийн жишигтэй харьцуулахад 2-3 дахин бага байгаа юм.

Сайд Г.Сайханбаяр хэлэхдээ "Өнөөдөр Батлан хамгаалахын сайдын төсвийн багцад 295,7 тэрбум төгрөг тусч байгаагаас 80 гаруй хувь нь шууд үйл ажиллагааны зардал буюу цалин хөлс, хангамж, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулагддаг. Салбарын төсөвт улсын хөрөнгө оруулалтын асуудал 3-4 хувийг эзэлдэг. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн төлөвлөлтөөр хэрэгжүүлдэг нь 15 хувь байх жишээтэй.

Тэгвээр бид бүхэн Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний шинэчлэлийг хэрхэн хийх вэ гэдэг бодлогоо тодорхой хэмжээгээр өөрчилж байгаа. Зэвсэгт хүчин улс орноо батлан хамгаалах ёстой гэсэн суурь концепцоо баримтлахын зэрэгцээ батлан хамгаалах салбар үйлдвэрлэгч, бүтээн байгуулагч байя. 2019 оны УИХ-ын намрын чуулганы төгсгөлд Зэвсэгт хүчний тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэснээр улс орны хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчнийг оролцуулах Барилга-инженерийн цэргийг

бий болгосон. Энэ төрлийн цэрэг улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа" гэдгийг онцолсон.

Ингэснээр Барилга-инженерийн цэрэг бүтээн байгуулалтад оролцож олсон тодорхой хувь орлогыг Зэвсэгт хүчнийхээ зэвсэг техникийн шинэчлэлд зарцуулах боломжтой аж. Үүсэн байгуулагдсанаасаа хойш буюу өнгөрсөн 100 жилийн түүхэнд манай улсын Зэвсэгт хүчин өөрсдөө буу, сум, галт хэрэглэл, техник үйлдвэрлэж байгаагүй. Тэгвэл 2020 оноос цэргийн инженер, техникийн ажилтнуудын хүчээр дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 3 төрлийн тагнуул, байлдааны зориулалттай хүнд, хөнгөн оврын техникүүдийг үйлдвэрлэсэн төдийгүй нисгэгчгүй нисэх хэрэгслүүдийг зохион бүтээсэн талаар Батлан хамгаалахын сайдын илтгэлд дурдагдсан. Түүнчлэн 1000 км-т холбоонд орох боломжтой "Мон-радио 1000" станцыг үйлдвэрлэсэн болохыг танилцууллаа. Өөрөөр хэлбэл, 1970, 80-аад оны үеийн аналог станцыг дижитал системд шилжүүлж, дээрх ажлуудыг хийж гүйцэтгэхэд Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас 2 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргасан гэдгийг салбарын сайд хэллээ. Энэ нь гадаадын улс орнуудаас авдаг цэргийн техникүүдэд зарцуулдаг мөнгөн дүнтэй харьцуулахад үлэмж бага төсөв аж.

Төгсгөлд нь Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Улс оронд амаргүй хүнд үе тохиож байна. Тиймээс бид төрийн бодлогыг ойлгож, дэмжиж ажиллах учиртай. Цаашид цаг наашилж, хэвийн горимд шилжихэд улс орны хэмжээнд батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлэхүйц хөгжлийн төсөвтэй болно гэдэгт итгэлтэй байна" гэв.

ЦАХИМ ШУУДАНД

ОЙН АРГА ХЭМЖЭЭ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЛО



Зэвсэгт хүчний 350 дугаар анги

ЗХЖШ-ын даргын 2011 оны дугаар тушаалаар Зэвсэгт хүчний 350 дугаар ангийг байгуулахаар шийдвэрлэн Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Дархан ноёны худаг" хэмээх газарт 2012 оны 6 дугаар сарын 15-ны өдөр шав тавих ёслол болж 2012 оны 10 дугаар сарын 28-нд бүтээн байгуулалтын ажил эхэлсэн түүхтэй. Ангийн арван жилийн ойн арга хэмжээ маш сайхан болж өндөрлөвөө.

Арван жилийн ойд хүндэт зочноор хошууч генерал Л.Гансэлэм мөн ангийн анхны захирагч, хурандаа Ж.Мөнхбаяр, хурандаа Д.Өлзийбаяр нар болон тус ангид ажиллаж байсан үе үеийн штабын дарга, ар талын дарга нар, офицер, ахлагч, ажилчин албан хаагчид уригдан ирлээ.

Ойн арга хэмжээний үеэр 2013 оны ахлагчийн сургуулийг төгсөж тус ангид анхны ахлагчаар томилогдон ирсэн ахлагч нар нэгдэн ангидаа гар бие сэтгэл зүрхээ шингээн бий болгосон энхийг сахиулагчийн дурсгалт хөшөөний нээлт болсон нь содон байлаа. Мөн энэ үеэр хүчит 32 бөхийн барилдаан болж, цэргийн арслан Жамбалдорж түрүүлж, аймгийн начин Дэмиддорж, сумын заан Бүүвэйжаргал нар шөвгөрлөө. Ангийн офицер, ахлагч, ажилчин албан хаагчид олон олон шагналын эзэд боллоо.



ӨӨДЛӨХ АЙЛ ҮҮДНЭЭСЭЭ



Зэвсэгт хүчний 256 дугаар анги цэргийн алба зохион байгуулах зааврын дагуу шалган нэвтрүүлэх байрыг шинэчлэн засварлаж дууслаа.

Дэслэгч Т.АЛТАНТУУЛ

Зэвсэгт хүчний 330 дугаар анги

ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТЭЭ ХИЙВ



2021-2022 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаагаа энэ сарын 1-ний өдөр ангийн жагсаалын талбайд ёслол төгөлдөр зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд ангийн захирагч, хурандаа Н.Бат-Эрдэнэ болон ангийн удирдлага нийт бие бүрэлдэхүүн оролцсон юм. Шинэ хичээлийн жилийн нээлтийн арга хэмжээнд ажил албандаа

манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй цэргийн алба хаагчид, ажилтан албан хаагчдыг шагнаж урамшууллаа. Мөн ангийн захирагч, удирдлагын зүгээс нийт тамирчин дайчдадаа хээрийн бэлтгэл сургуулилтаа тав тухтай хангахад нь зориулж өргөө цагаан гэрийг ангийн ахлагч, тэргүүн ахлагч Б.Хишигдалайд гардуулан өгч, үйл ажиллагааны төгсгөлд ангийн үлээвэр найрал хөгжмийн бие бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн дэргэдэх амьд хөгжмийн "Соёрхол" хамтлагийн урлагийн хэсэгчилсэн тоглолтыг толилууллаа.

